

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**20... оны .. дугаар
сарын ...-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Автотээврийн тухай хууль тогтоомж

2.1. Автотээврийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Авто замын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон эдгээр хуульд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн, хуулийн этгээд болон гадаад улсын иргэн, хуулийн этгээд автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах, түүнд хяналт тавихад энэ хуулиар зохицуулна.

3.2. Тээвэрлэлтийн тусгай горим шаардсан ачаа тээвэрлэхтэй холбогдсон нийтлэг харилцааг энэ хуулиар, бусад харилцааг холбогдох салбарын хуулиар тус тус зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “автотээвэр” гэж зорчигч болон ачаа тээвэрлэлт, автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон цогц үйл ажиллагааг;

4.1.2. “автотээврийн хэрэгсэл” гэж авто замаар зорчигч, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, чиргүүл, хагас чиргүүлийг;

4.1.3. “автотээврийн хэрэгслийн ашиглалт” гэж тээврийн хэрэгслийг бүртгэх, хадгалах, техникийн үйлчилгээ, засвар хийх, шатахуун, тосолгооны болон ашиглалтын бусад материалаар хангах, техникийн бүрэн бүтэн байдал,

найдварт ажиллагааг хангахад чиглэгдсэн техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг;

4.1.4. “автомашин үйлдвэрлэл” гэж тээврийн хэрэгсэл, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, зураг төсөл боловсруулах зэрэг автомашин үйлдвэрлэлтэй холбоотой цогц үйл ажиллагааг хэлнэ;

4.1.5. “автомашин, эд ангийн дахин боловсруулалт” гэж ашиглалтын хугацаа дууссан буюу стандартын шаардлага хангахгүй болсон тээврийн хэрэгсэл, түүний эд ангийг технологийн дагуу устгах, сэргээн засварлах үйл ажиллагааг;

4.1.6. “автотээврийн дэд бүтэц” гэж тээвэрлэлтийн үйл ажиллагааг үр ашигтай, тогтвортой зохион байгуулахад зориулагдсан авто зам, замын байгууламж, ачаа, зорчигчийн терминал, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол, талбай, авто замын дагуух үйлчилгээний цогц байгууламжийг;

4.1.7. “ачаа, зорчигчийн терминал” гэж зорчигч хүлээн авах, үдэн гаргах, буулгах, суулгах, ачааг цуглуулах, хадгалах, савлах, ангилах, ачиж буулгахтай холбогдсон цогц үйлчилгээ үзүүлэх байгууламжийг;

4.1.8. “ачаа” гэж автотээврийн хэрэгслээр тээвэрлэхээр хүлээж авсан болон тээвэрлэж буй эд зүйлсийг;

4.1.9. “байнгын тээвэрлэлт” гэж эрх бүхий байгууллагын баталсан замнал, тодорхой цагийн хуваарийн дагуу гүйцэтгэж байгаа тээвэрлэлтийг;

4.1.10. “байнгын бус тээвэрлэлт” гэж энэ хуулийн 4.1.9-т зааснаас бусад тээвэрлэлтийг;

4.1.11. “дамжин өнгөрөх тээвэрлэлт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээвэрлэлтийг;

4.1.12. “жуулчин тээвэрлэлт” гэж жуулчинд үзүүлж буй аялал жуулчлалын тухай хуулийн 3.1.1 дэх заалтад хамаарах тээвэрлэлтийг;

4.1.13. “зорчигч тээвэр” гэж хүн тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслээр гүйцэтгэж буй үйлчилгээг;

4.1.14. “зорчигч” гэж автотээврийн хэрэгслээр зорчиж яваа хүнийг;

4.1.15. “мэргэшсэн жолооч” гэж тээвэрлэлтийн тодорхой ажил үйлчилгээ эрхлэх зорилгоор эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу сургалтын хөтөлбөрт хамрагдан мэргэжлийн үнэмлэх авсан этгээдийг;

4.1.16. “мөсөн замын тээвэр” гэж гол, мөрөн, нуурын ус хөлдсөн үед тогтоосон хугацаанд мөсөн дээгүүр хийх тээвэрлэлтийг;

4.1.17. “нийтийн тээвэр” гэж эрх бүхий байгууллагаас тогтоосон чиглэл, замнал, цагийн хуваарийн дагуу зохион байгуулалттай гүйцэтгэж байгаа тээвэрлэлтийг;

4.1.18. “орон нутгийн тээвэрлэлт” гэж аймаг, хотуудын хооронд болон тухайн аймаг, сумын нутаг дэвсгэрт хийх тээвэрлэлтийг;

4.1.19. “ослыг шинжлэн шалгах” гэж тээвэрлэлтэд гарч болзошгүй осол, зөрчил, техникийн саатлаас урьдчилан сэргийлэх, гарсан ослын шалтгааныг тогтоох, аюулгүй байдлын зөвлөмж бэлтгэх үйл ажиллагаа;

4.1.20. “техникийн хяналтын үзлэг” гэж тээврийн хэрэгслийн техникийн байдал стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд үзлэг хийж шалгах, тодорхойлох, үнэлэх үйл ажиллагааг;

4.1.21. “технологийн тээвэрлэлт” гэж Авто замын тухай хуулийн заасан тусгай зориулалтын замаар хийгдэж буй тээвэрлэлтийг;

4.1.22. “тээвэрлэлт” гэж автотээврийн хэрэгслээр зорчигч болон ачааг нэг газраас нөгөө газарт шилжүүлэн зөөхтэй холбогдсон ажил, үйлчилгээг;

4.1.23. “тээврийн хэрэгсэл” гэж Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасныг;

4.1.24. “тээвэрлүүлэгч” гэж ачаа илгээгч болон ачаа хүлээн авагчийг;

4.1.25. “тээвэрлэгч” гэж тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийг;

4.1.26. “улс хоорондын тээвэрлэлт” гэж Монгол Улсын хилийг нэвтрэн хийх тээвэрлэлтийг;

4.1.27. “хот хоорондын тээвэрлэлт” гэж нийслэлээс аймаг, хот, хилийн боомт хүртэл, аймаг, хот болон хилийн боомтоос нийслэл хүртэл хийгдэх тээвэрлэлтийг;

4.1.28. “хот доторхи болон хот орчмын тээвэрлэлт” гэж тухайн хотын нутаг дэвсгэрт хийх тээвэрлэлтийг.

5 дугаар зүйл. Автотээврийн салбарын үйл ажиллагааны үндсэн зарчим

5.1. Автотээврийн салбарын үйл ажиллагаанд дор дурдсан зарчмыг баримтална:

5.1.1. тээврийн үйл ажиллагаа нь нэгдмэл, тээврийн бусад салбарын үйл ажиллагаатай уялдсан байх;

5.1.2. тээврийн үйлчилгээ нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага, зах зээлийн эрэлтийг хангасан байх;

5.1.3. үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангасан, тогтвортой байх;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

АВТОТЭЭВРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

6 дугаар зүйл. Төрийн зохицуулалт

6.1. Автотээврийн салбарыг үр ашигтай, тогтвортой хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг тодорхойлох, хууль эрх зүйн орчноор хангах, үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, нэгдсэн зохицуулалтаар хангах, хяналт тавих байдлаар төрийн зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

6.2. Төрийн эрх бүхий байгууллагаар дамжуулан дараах удирдлагаар хангана:

6.2.1. шинжлэх ухаан, технологийн дэвшилд суурилсан, нийгэм, эдийн засгийн эрэлтийг хангахад чиглэгдсэн автотээврийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, судалгаа, шинжилгээ хийх;

6.2.2. автотээврийн салбарт эрх зүйн таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

6.2.3. нийгэм, эдийн засгийн эрэлтэд нийцсэн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

6.2.4. тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн эрх ашиг, зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавих;

6.2.5. тээврийн хэрэгслийн техникийн байдалд хяналт тавих

6.2.6. тээврийн салбарт олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх.

6.3. Тээврийн салбарын бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдлыг төрийн зүгээс хангана.

7 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

7.1. Монгол Улсын Их Хурал автотээврийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. автотээврийн салбарын хөгжлийн үзэл баримтлалыг тодорхойлох;

7.1.2. өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар олон улсын автотээврийн холбогдолтой гэрээ соёрхон батлах;

7.1.3. автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах;

7.1.4. хуульд заасан бусад бүрэн эрх

8 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

8.1. Засгийн газар автотээврийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. автотээврийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, автотээврийн оновчтой дэд бүтэц, тээврийн үр ашигтай нэгдсэн сүлжээ, автотээврийн дэд бүтцийг хөгжүүлэх;

8.1.2. автотээврийн салбарын хөгжлийн үзэл баримтлал, автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

8.1.3. автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих захиргааны хяналтыг хэрэгжүүлэх, автотээврийн хяналтын дүрмийг батлах;

8.1.4. тусгай зориулалтын авто замаар тээвэрлэлт гүйцэтгэх дүрмийг батлах;

8.1.5. автотээврийн зохицуулах хороо байгуулах, дүрмийг нь батлах;

8.1.6. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

9 дугаар зүйл. Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

9.1. Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. автотээврийн салбарын хөгжлийн үзэл баримтлал, автотээврийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

9.1.2. автотээврийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Ерөнхийлөгч, Улсын Их хурал, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

9.1.3. автотээврийн салбарт дэвшилтэт техник, технологи нутагшуулах, автотээврийн салбарын хүний нөөцийг бэлтгэн мэргэшүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх;

9.1.4. автотээврийн салбарын хөрөнгө оруулалтыг нийгэм-эдийн засгийн ач холбогдол, үр өгөөжөөр нь эрэмбэлэн төлөвлөх;

9.1.5. автотээврийн салбарт мөрдөх багц дүрэм, норм, норматив, аргачлалыг батлах, тэдгээрийн биелэлтийг хангуулах;

9.1.6. олон улсын тээврийг хөгжүүлэх зорилгоор гадаад улс, олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллах;

9.1.7. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

9.2. Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дэргэдээ сургалт, судалгаа шинжилгээний байгууллагатай байж болно.

10 дугаар зүйл. Автотээврийн зохицуулах хороо

10.1. Өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн автотээврийн зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зохицуулах, хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй Автотээврийн зохицуулах хороо /цаашид "Зохицуулах хороо" гэх/ ажиллана.

10.2. Зохицуулах хороо нь дарга, орон тооны бус 6 гишүүнээс бүрдэнэ.

10.3. Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилно.

10.4. Зохицуулах хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна. Зохицуулах хорооны гишүүдийн анхны томилгоог 2, 4, 6 жилээр хийж, цаашид 6 жилийн хугацаагаар томилно.

10.5. Зохицуулах хорооны даргыг нэг удаа улируулан томилж болно.

10.6. Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, дараахь шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг Зохицуулах хорооны дарга, гишүүнээр томилно:

10.6.1. автотээврийн болон эрх зүй, тээврийн удирдлагын чиглэлээр дээд боловсролтой, мэргэшсэн, ажлын дадлага, туршлагатай, удирдан зохион байгуулах чадвартай;

10.6.2. Зохицуулах хорооны дарга, гишүүн нь үйлчлэгчийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаар эзэмшигч, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд байж болохгүй;

10.6.3. Зохицуулах хорооны дарга, гишүүд автотээврийн улсын байцаагчийн эрхтэй байна.

10.7. Зохицуулах хороо нь ажлын албатай байх ба хорооны дэргэд зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллуулж болно.

10.8. Зохицуулах хорооны ажлын албаны орон тоо, дүрмийг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөж, Ерөнхий сайд батална.

10.9. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс болон автотээврийн ашиглалт, үйлчилгээний төлбөрөөс санхүүжинэ.

11 дүгээр зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх

11.1. Зохицуулах хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1. автотээврийн талаар төрөөс баримталж буй бодлого, эрх зүйн талаар санал боловсруулах, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах;

11.1.2. хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, түүнийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавих, гэрээ байгуулах;

11.1.3. тээвэрлэлтийн болон техник ашиглалттай холбоотой тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл, шаардлагыг тогтоох, баталгаажуулах;

11.1.4. тээвэрлэлтийн осол зөрчлийг шинжлэн шалгах, зөвлөмж гаргах;

11.1.5. тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;

11.1.6. автотээврийн үйлчилгээний тариф тогтоох аргачлалыг батлах, зах зээлд давамгайлж буй үйлчилгээний тарифыг хянах;

- 11.1.7. автотээврийн зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх;
- 11.1.8. тээвэрлэлтийн сүлжээний нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх;
- 11.1.9. тээвэрлэлтийн замнал, замналын зураглалыг батлах, хяналт тавих;
- 11.1.10. зохицуулалтын үйлчилгээний хөлсний хувь хэмжээг тогтоох;
- 11.1.11. тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх;
- 11.1.12. автотээврийн салбарт шударга бус өрсөлдөөн үүсэхээс сэргийлэх зорилгоор тариф, бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ, гэрээний өөрчлөлтийг хянаж, санал, дүгнэлт гаргах;
- 11.1.13. автотээврийн хэрэгслийн төрөл, зориулалтыг нь харгалзан техникийн хяналтын үзлэгт оруулах төлбөрийн жишгийг ялгавартай тогтоох;
- 11.1.14. арилжааны тээвэрлэгчийг бүртгэх;
- 11.1.15. зам тээврийн осол, гамшиг, аюулт үзэгдэлд өртсөн автотээврийн хэрэгсэлд дүгнэлт гаргах;
- 11.1.16. автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон бусад ажил;
- 11.1.17. бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар, зөвлөмж баталж хэрэгжилтэд хяналт тавих.

10 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

10.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга автотээврийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 10.1.1. автотээврийн салбарын хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, автотээврийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар болон автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;
- 10.1.2. автотээврийн салбарын хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлоготой уялдуулан харьяалах нутаг дэвсгэртээ автотээврийг хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- 10.1.3. орон нутгийн, хот доторх болон хот орчмын нийтийн тээвэр, цаг үеийн шуурхай тээвэрлэлтийг улсын захиалга, даалгаврын дагуу нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

10.1.4. хүн амын нутагшил, байршлын онцлог, зорчигч тээврийн хэрэгцээнээс шалтгаалан өрсөлдөх боломжгүй чиглэлд орон нутагт нийтийн тээврийг зохих нөхөн төлбөр олгох нөхцөлтэйгөөр тээвэрлэгчтэй гэрээ хийж гүйцэтгүүлэх;

10.1.5. тухайн нутаг дэвсгэрт орших гол, мөрөн, нуурын ус хөлдсөн үед орон нутгийн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллага, авто замын байгууллагатай хамтран мөсний даацыг тодорхойлж, орон нутгийн цаг уурын байдлыг харгалзан мөсөн дээгүүр хийх тээвэрлэлтийн эхлэх, дуусах хугацаа, чиглэлийг тогтоон тэмдэгжүүлж тээвэрлэгчдийг мэдээллээр хангах;

10.1.6. нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж байгаа хараагүй хүнд зориулж буудлыг зарлах, сонсголын бэрхшээлтэй иргэнд зориулж буудал бүрд нэр, хаяг, чиглэлийг бичмэл болон зургийн хэлбэрээр байрлуулах, өөрчлөх арга хэмжээг зохион байгуулах;

10.1.7. байгалийн гамшиг, сүйрэл, ослын хор уршгийг арилгах, автотээврийн дэд бүтцийн хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад өөрийн эрх мэдлийн хүрээнд дэмжлэг үзүүлэх;

10.1.8. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

11 дүгээр зүйл. Автотээврийн нийтлэг багц дүрэм

11.1. Автотээврийн нийтлэг багц дүрмээр дараах дүрэм, журмыг тогтооно:

11.1.1. ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа;

11.1.2. автотээврийн дэд бүтэц ашиглах үйл ажиллагаа;

11.1.3. автотээврийн салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаа;

11.1.4. автотээврийн салбарын мэдээллийн нэгдсэн сан хөтлөх, уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөхтэй холбогдсон үйл ажиллагаа;

11.1.5. автомашин, эд ангийг үйлдвэрлэх, дахин боловсруулах үйл ажиллагаа;

11.1.6. дамжин өнгөрөх тээврийн үйлчилгээний хураамж;

11.1.7. жолоочийн хөдөлмөр амралтын горимыг тогтоох;

11.1.8. мэргэшсэн жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох үйл ажиллагаа;

11.1.9. мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаа;

11.1.10. тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрөл олгох, сонгон шалгаруулах үйл ажиллагаа;

11.1.11. тээвэр зуучлалын үйл ажиллагаа;

11.1.12. тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагаа;

11.1.13. тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаа;

11.1.14. төлбөрийн цахим системийг нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглах үйл ажиллагаа;

11.1.15. тээвэрлэлтийн баримт бичгийг ашиглах үйл ажиллагаа;

11.1.16. зам тээврийн осол, гамшиг, аюулт үзэгдэлд өртсөн автотээврийн хэрэгсэлд дүгнэлт гаргах үйл ажиллагаа;

11.1.17. тээвэрлэлтийн ослыг шинжлэн шалгах үйл ажиллагаа.

11.2. Автотээврийн салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааны журам, жолоочийн хөдөлмөр амралтын горимыг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Автотээврийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн хамтран батална.

11.3. Автомашин, эд ангийг үйлдвэрлэх, дахин боловсруулах үйл ажиллагааны журмыг Байгаль орчны болон Үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн, Автотээврийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн хамтран батална.

11.4. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэх журам, нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэхийг хориглосон барааны жагсаалтыг Засгийн газар тогтооно.

11.5. Төлбөрийн цахим системийг нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглах үйл ажиллагааны журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монгол банк, Санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

11.6. Бусад дүрэм, журмыг автотээврийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТЭЭВЭРЛЭЛТ

12 дүгээр зүйл. Тээвэрлэлтийн төрөл

12.1. Тээвэрлэлт нь дор дурдсан төрөлтэй байна:

12.1.1. зорчигч тээвэрлэлт;

12.1.2. ачаа тээвэрлэлт.

13 дугаар зүйл. Тээвэрлэлтийн ангилал, зохицуулалт

13.1. Тээвэрлэлтийг нутаг дэвсгэрийн хүрээгээр нь дор дурдсан байдлаар ангилна:

13.1.1. олон улсын тээвэрлэлт;

13.1.2. дотоодын тээвэрлэлт.

13.2. Тээвэрлэлтийг давтамжаар нь байнгын болон байнгын бус гэж ангилна.

13.3. Олон улсын тээвэрлэлт нь дамжин өнгөрөх тээвэрлэлт, улс хоорондын тээвэрлэлт гэсэн төрөлтэй байх бөгөөд тээвэрлэлтийн чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг олон улсын автотээврийн харилцааны гэрээ, хэлэлцээрийг үндэслэн автотээврийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн гаргаж, Автотээврийн зохицуулах хороо хэрэгжүүлнэ.

13.4. Дотоодын тээвэрлэлт нь хот хоорондын тээвэрлэлт, орон нутгийн тээвэрлэлт, хот болон хот орчмын тээвэрлэлт гэсэн төрөлтэй байх бөгөөд хот хоорондын нийтийн тээврийн чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг тухайн аймгийн Засаг даргатай зөвшилцөн автотээврийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн гаргаж, Автотээврийн зохицуулах хороо хэрэгжүүлнэ.

13.5. Орон нутгийн нийтийн тээврийн чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг тухайн аймгийн Засаг дарга гаргаж Засаг даргын эрх олгосон байгууллага хэрэгжүүлнэ.

13.6. Хотын доторх болон хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг тухайн аймаг, хотын Засаг дарга гаргах бөгөөд аймаг, нийслэлийн Засаг даргын эрх олгосон байгууллага хэрэгжүүлнэ.

13.7. Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэхээс бусад арилжааны зориулалттай тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх бол тогтоосон журмын дагуу Автотээврийн зохицуулах хороонд бүртгүүлсний үндсэн дээр тээвэрлэлт гүйцэтгэнэ.

13.8. Хот доторхи болон хот орчмын тээврийн үйлчилгээнд шатдаг хий, цахилгаан, байгаль орчинд ээлтэй бусад эх үүсвэрээр ажилладаг болон тэдгээрийн хосолмол хэрэглээ бүхий автотээврийн хэрэгсэл ашиглана.

13.9. Тээвэрлэлтийг Иргэний хууль болон энэ хуульд нийцсэн гэрээний дагуу гүйцэтгэнэ.

14 дугаар зүйл. Тээвэрлэгчийн эрх, үүрэг

14.1. Тээвэрлэгч нь дараах эрх эдэлнэ:

14.1.1. авто замын байгууллагаас авто зам, гүүрийг тээврийн хэрэгсэл зорчиход саадгүй байлгахыг шаардах, авто зам гүүрийн ашиглалтын нөхцөл хангаагүйгээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;

14.1.2. тээврийн хөлс төлөөгүй буюу жолооч, кондуктор шаардахад тээврийн хөлс төлөхгүй байгаа зорчигч мөн тээвэрлэлтийн нөхцөлийн дагуу бэлтгээгүй ачааг тээвэрлэхээс татгалзах;

14.1.3. тээвэрлэлтийн гэрээгээр хүлээсэн нөхцөл, тээвэрлэлтийн үнэ тарифыг тээвэрлүүлэгчээс шаардах;

14.1.4. зорчигч тээврийн хэрэгслийн жолооч нь нийгмийн хэв журам сахих, тээврийн үйлчилгээний дүрэм, журмыг биелүүлэх шаардлагыг зорчигчид тавих.

14.2. Тээвэрлэгч нь дараах үүрэг хүлээнэ:

14.2.1. өөрийн тээвэрлэлтийн үйлчилгээний талаархи үнэн зөв мэдээллээр тээвэрлүүлэгчийг хангах;

14.2.2. тээвэрлэлтийг тухайн ангиллын автотээврийн хэрэгслийг жолоодох эрхтэй, мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх;

14.2.3. авто зам, замын байгууламж болон автотээврийн дэд бүтцийг техникийн нөхцөл шаардлагын дагуу ашиглах;

14.2.4. зөвхөн өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслээр нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх;

14.2.5. тээвэрлэлттэй холбоотой үнэн зөв мэдээллээр тээвэрлүүлэгчийг хангах.

15 дугаар зүйл.Тээвэрлүүлэгч, зорчигчийн эрх, үүрэг

15.1. Тээвэрлүүлэгч, зорчигч нь дараахь эрх эдэлнэ:

15.1.1. тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангаагүй, зориулалтын бус тээврийн хэрэгслээр үйлчлүүлэхээс татгалзах;

15.1.2. нийтийн тээврийн тогтоосон чиглэл, үйлчилгээний цагийн хуваарь баримтлахыг тээвэрлэгчээс шаардах;

15.1.3. тээвэрлэлтийн үнэ тариф, замын чиглэл, үйлчилгээний цагийн хуваарь, ачаа хүргэх хугацааны талаар үнэн зөв мэдээлэл авах;

15.1.4. тээвэрлэлтийн гэрээнд зааснаас бусад тохиолдолд улс, хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч нь өвчлөх зэрэг хүндэтгэх шалтгаанаар худалдан авсан зорчих тасалбарт заасан чиглэлд зорчиж чадахгүй болсон буюу хүрэх газартаа хүрээгүй буусан тохиолдолд замын үлдсэн хэсэгт ногдох тээврийн хөлсийг тээвэрлэгчээс буцааж авах;

15.2. Тээвэрлүүлэгч, зорчигч нь дараахь үүрэг хүлээнэ:

15.2.1. ачааны савлалт, баглаа, боодол, бэхэлгээг стандартын дагуу хийж, нэр төрөл, илгээх чиглэлээр нь ялган тээвэрлэхэд бэлтгэх;

15.2.2. ачааг ачих, буулгах зам, талбайг автотээврийн хэрэгсэл явахад саадгүй байлгах;

15.2.3. ачих, буулгах машин механизм, нэмэгдэл төхөөрөмж, хүн хүчийг бэлэн байлгаж ачааг тогтоосон хугацаанд ачих, буулгах, өөрийн хаягтай буюу гэрээт ачааг хүлээн авах;

15.2.4. ачааг тээвэрлэх, хадгалах тухай мэдээллээр тээвэрлэгчийг хангах;

15.2.5. ачааг ачсан, хүлээн авсан тухайгаа тээврийн баримт бичигт тэмдэглэж баталгаажуулан тээвэрлэгчид олгох;

15.2.6. нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч нь зорчих тасалбарыг худалдан авах;

15.2.7. нийтийн тээврээр зорчихдоо бусдын амь нас, эрүүл мэндэд аюул, гэм хор учруулж болзошгүй эд зүйлийг авч явахгүй байх;

15.2.8. нийтийн тээврээр зорчихдоо автотээврийн хэрэгслийг эвдэж, гэмтээхгүй байх;

15.2.9. зорчигч нь улс, хот хооронд, орон нутагт зорчихдоо иргэний үнэмлэх, холбогдох бусад баримт бичиг, зорчих тасалбарыг биедээ авч явах, тэдгээрийг шалгах эрх бүхий хүмүүсийн шаардлагаар үзүүлэх.

16 дугаар зүйл. Зорчигч тээвэрлэлт

16.1. Зорчигч тээвэр нь дараах төрөлтэй байна:

16.1.1. нийтийн тээвэрлэлт;

16.1.2. жуулчин тээвэрлэлт;

16.1.3. арилжааны зориулалттай тээвэрлэлт.

16.2. Таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээг тогтоосон замнал, цагийн хуваариар зохицуулах бөгөөд үйлчилгээний цагийн хуваарь нь зорчигчдоос бага хугацаа зарцуулж ая тухтай, аюулгүй зорчих нөхцөл, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, жолоочийн хөдөлмөрийн хэвийн нөхцөл, автотээврийн хэрэгслийг оновчтой ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.

16.3. Таксийн үйлчилгээ нь тогтоосон замнал, чиглэл, цагийн хуваарь харгалзахгүй, тоолуурын тусламжтайгаар зорчигчийн нийт зорчсон замаас хамааран тээвэрлэлтийн үнэ төлөх бөгөөд зөвхөн хот болон хот орчимд үйлчилнэ.

16.4. Жуулчин тээврийн үйлчилгээ нь жуулчдын аяллын хөтөлбөрийн дагуу зорчих үйлчилгээг үзүүлнэ.

16.5. Арилжааны зориулалттай тээвэрлэлтэд сургуулийн хүүхэд, байгууллагын ажилчид тээвэрлэх болон иргэд аж ахуйн нэгж байгууллагатай тээвэрлэлтийн гэрээний үндсэн дээр төлбөртэй хийгдэж буй тээвэрлэлтийн үйлчилгээ хамаарна.

16.6. Зорчигч тээврийн үйлчилгээг зохих стандартад нийцсэн, зүүн гар талдаа жолооны хүрдтэй, зорчигчийг баруун гар тал руугаа буулгаж, суулгах нөхцөлийг хангасан автотээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ.

16.7. Нийтийн тээврийн үйлчилгээнд төлбөрийн цахим систем ашиглаж болно.

16.8. Энэ хуулийн 16.7-д заасан төлбөрийн цахим систем улсын хэмжээнд нэгдмэл байна.

17 дугаар зүйл. Ачаа тээвэрлэлт

17.1. Ачаа тээвэрлэлтийг техникийн шаардлага хангасан зөвхөн зориулалтын тээврийн хэрэгслээр тухайн тээвэрлэлтэд тавигдах нөхцөл шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.

17.2. Олон улсын байнгын ачаа тээврийн үйлчилгээ нь олон улсын автотээврийн харилцааны хүрээнд хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын харилцан тохиролцсон хугацаа, эхлэх, хүрэх цэг, нэвтрэх боомт, дундын зогсоол бүхий замналын дагуу хийгдэнэ.

17.3. Олон улсын байнгын бус ачаа тээврийн үйлчилгээ олон улсын автотээврийн харилцааны хүрээнд хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын харилцан тохирсон замналын дагуу хийгдэнэ.

17.4. Дамжин өнгөрөх тээвэрлэлт нь зөвхөн автотээврийн харилцааны хүрээнд хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын харилцан тохирсон Монгол Улсын олон улсын чанартай хилийн боомт, замналын дагуу хийгдэнэ.

17.5. Дамжин өнгөрөх тээвэрлэлт нь сэлгэн тээвэрлэх, хадгалах, нэгтгэх, тээврийн төрлийг өөрчлөх, эсхүл эдгээр үйлдлийг гүйцэтгэхгүйгээр шууд дамжин өнгөрөх байдлаар хийгдэнэ.

17.6. Тээвэрлэлтийн үйлчилгээг зөвхөн хууль тогтоомжийн дагуу эрх, зөвшөөрөл авсан, бүртгүүлсэн иргэн аж ахуйн нэгж байгууллага гүйцэтгэнэ.

18 дугаар зүйл. Автотээврийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа

18.1. Автотээврийн аюулгүй байдал нь автотээврийн үйл ажиллагааг хөндлөнгийн хууль бус үйл ажиллагаанаас хамгаалахтай холбогдсон цогц арга хэмжээ байна.

18.2. Автотээврийн аюулгүй ажиллагаа нь автотээврийн үйл ажиллагааг хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөнд хохирол учруулахгүйгээр гүйцэтгэх нөхцөл байдал, чадварыг хангасан байна.

18.3. Автотээврийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа нь тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн болон тээврийн бусад үйлчилгээ хэрэглэгчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн нэгдмэл байна.

18.4. Автотээврийн дэд бүтцийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг өмчлөгч, эзэмшигч хариуцах бөгөөд аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангаагүй дэд бүтэц ашиглан тээвэрлэлтийн үйл ажиллагаа гүйцэтгэхийг хориглоно.

18.5. Тээвэрлэлтийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг тээвэрлэгч хариуцах бөгөөд аюулгүй байдлыг хангаагүй, зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэлт гүйцэтгэхийг хориглоно.

18.6. Тээвэрлэлтийн аюулгүй байдал нь аюулгүй ажиллагаа нь ая тухтай, шуурхай, хүртээмжтэй тээвэрлэлтийн нөхцөл бүрдсэн байдлаар хангагдана.

18.7. Автотээврийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тээврийн төрөл тус бүрийн стандартаар тогтооно.

19 дүгээр зүйл. Тээврийн ослыг шинжлэн шалгах

19.1. Автотээврийн салбарын аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах, ослоос урьдчилан сэргийлэх, зам тээврийн осол зөрчлийг шалгах, шалтгаан нөхцөлийг тогтоох, дүгнэлт хийх, тухайн шалтгаан нөхцөлөөр ахин осол гаргахгүй байх аюулгүй ажиллагааны зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааг хийнэ.

19.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан нэг удаагийн зам тээврийн ослын улмаас 4 болон түүнээс дээш хүн нас барсан болон эд материалын онц их хэмжээний хохирол учирсан тохиолдолд ослыг шинжлэн шалгах ажиллагаа хийгдэнэ.

19.3. Шинжлэн шалгах ажиллагаа нь хараат бус, бие даасан, хууль дээдэлсэн зарчимд тулгуурлан, ослын шалтгааныг үнэн бодитоор тогтоох бөгөөд хэн нэгэн этгээдийн гэм буруутайг тогтоох, хариуцлага тооцоход чиглэгдэхгүй.

19.4. Ослыг шинжлэн шалгах эрх бүхий байгууллага, түүний шинжлэн шалгагчаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн шаардлагатай туслалцаа үзүүлэх, зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

19.5. Ослыг шинжлэн шалгасан тайлан, дүгнэлт нь эрүүгийн болон иргэний шүүн таслах ажиллагаанд аливаа этгээдийг буруутгах нотлох баримтаар ашиглахыг хориглоно.

20 дугаар зүйл. Тээвэрлэлтийн үнэ тариф

20.1. Тээвэрлэлтийн үнийг оролцогч талууд үйлчилгээний үнэ тариф тогтоох аргачлалд нийцүүлэн гэрээгээр тохиролцоно.

20.2. Хот доторх болон хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

20.3. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийн үйлчилгээний хураамжийн хэмжээг Засгийн газар тогтооно.

20. дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн дайчлах, Тээвэрлэлтийг түр хугацаагаар зогсоох, хязгаарлах

20.1. Автотээврийн хэрэгслийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу дайчилж болно.

20.2. Хууль тогтоомжид зааснаас бусад нөхцөлд автотээврийн хэрэгслийг дайчлахыг хориглоно.

20.3. Гамшиг, аюулт үзэгдэл болон аюул тохиолдсон нөхцөлд тээвэрлэлтийн ажлыг түр хугацаагаар зогсоох буюу хязгаарлах шийдвэрийг дараах эрх бүхий албан тушаалтан гаргаж нийтэд мэдээлнэ.

20.3.1. олон улсын тээвэрлэлтийн чиглэлд улсын байнгын онцгой комиссын шийдвэр, саналыг үндэслэн автотээврийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн;

20.3.2. дотоодын тээвэрлэлтийн чиглэлд нийслэл, тухайн аймаг, сумын засаг дарга.

20.4. Хууль тогтоомжид зааснаас бусад үндэслэлээр тээвэрлэлтийг зогсоох, хязгаарлах, автотээврийн хэрэгслийг саатуулахыг хориглоно.

21. дугаар зүйл. Тээвэр зуучлал

21.1. Байнгын ачаа тээвэрлэлтийг зуучлагчаар дамжуулан эрхэлж болно.

21.2. Зуучлагч нь байнгын ачаа тээвэрлэлт эрхлэгчийг тээвэрлүүлэгчтэй холбон зуучлах, үйл ажиллагааг нь уялдуулах, тээвэрлэлтийн баримт бичгийг бүрдүүлэх, тээвэрлэлтийн явц, аюулгүй байдалд хяналт тавих, тээвэрлэлтээс үүсэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулна.

21.3. Тээвэр зуучлагчийн үйл ажиллагааг “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу итгэмжлэгдсэн байгууллага гүйцэтгэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

АВТОТЭЭВРИЙН ДЭД БҮТЭЦ

22. дугаар зүйл. Автотээврийн дэд бүтцийн бүрэлдэхүүн

22.1. Автотээврийн дэд бүтцэд нь тээвэрлэлтийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, шуурхай байдал, тав тухтай үйлчилгээг үзүүлэх, тээвэрлэлтийг хямд, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

22.2. Автотээврийн дэд бүтэц нь тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээ, төлөвлөлттэй уялдах бөгөөд үйлчлэх хүрээнээсээ хамааран олон улсын, бүс нутгийн, орон нутгийн гэсэн төрөлтэй, олон улсын болон үндэсний тээврийн нэгдсэн сүлжээнд холбогдсон байна.

22.3. Ачааны терминал нь өөрийн нэгдсэн сүлжээг ашиглан дотоодын, экспорт, импортын болон дамжин өнгөрөх ачааг хүлээн авах, хүлээлгэн өгөх, хадгалах, шилжүүлэн ачих, мэдээллийн сан бүрдүүлэх болон зохион байгуулалтын бусад үйлчилгээг үзүүлнэ.

22.4. Зорчигчийн терминал нь зорчигчид ая тухтай үйлчилгээ үзүүлэх, тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах үйлчилгээг үзүүлнэ.

22.5. Авто замын дагуух үйлчилгээний байгууламж нь жолооч болон зорчигчдод аялалын явцад шаардлагатай үйлчилгээ үзүүлэх, тээврийн хэрэгслийг техникийн

засвар үйлчилгээ, шатах тослох материалаар хангах зэрэг үйлчилгээг нэг дор үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

22.6. Олон улсын чанартай автотээврийн дэд бүтэц нь олон улсын болон бүс нутгийн тээвэр логистикийн сүлжээнд холбогдсон, хоёр болон түүнээс дээш тээврийн төрлийн үйлчилгээнд зориулагдсан, олон улсын болон бүс нутгийн, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлнэ.

22.7. Бүс нутгийн чанартай автотээврийн дэд бүтэц нь бүс нутгийн, орон нутгийн тээврийн логистикийн сүлжээнд холбогдсон, хоёр болон түүнээс дээш тээврийн төрлийн үйлчилгээнд зориулагдсан, бүс нутгийн, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлнэ.

22.8. Орон нутгийн чанартай автотээврийн дэд бүтэц нь орон нутгийн тээврийн логистикийн сүлжээнд холбогдсон тээврийн нэг төрлийн үйлчилгээнд зориулагдсан, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлнэ.

22.9. Ачааны терминал нь үйлдвэрлэл, үйлчилгээний бүсэд ойрхон, эдийн засгийн ач холбогдол бүхий тээврийн нэгдсэн сүлжээний зангилаа хэсэгт байрласан, тээврийн логистикийн нэгдсэн сүлжээнд холбогдсон байна.

22.10. Автотээврийн дэд бүтцийн үйл ажиллагаа, үйлчилгээнд тавигдах шаардлага, зэрэглэлийг стандартаар тогтооно.

ТАВ ДУГААР БҮЛЭГ

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТ

23 дугаар зүйл. Авто үйлчилгээ эрхлэгч

23.1. Авто үйлчилгээнд автотээврийн хэрэгслийн ашиглалт, найдвартай ажиллагааг хангахтай холбоотой дараах үйл ажиллагаа хамаарна:

23.1.1. автотээврийн хэрэгсэл болон түүний сэлбэг хэрэгсэл, тос тосолгооны материалын импорт, үйлдвэрлэл, худалдаа;

23.1.2. авто техникийн засвар үйлчилгээ;

23.1.3. автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой бусад үйлчилгээ.

23.2. Авто үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг стандартаар тогтооно.

23.3. Авто үйлчилгээ эрхлэгч дараах үүрэг хүлээнэ:

23.3.1. үйл ажиллагаанд тавигдаж буй стандартын шаардлагыг хангаж байгаа эсэхэд тохирлын үнэлгээ хийлгэж баталгаажуулах;

23.3.2. стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмжийг засвар үйлчилгээнд ашиглах;

23.3.3. хэрэглэгчдэд худалдах сэлбэг хэрэгсэл, тос, тосолгооны материал нь Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн гарал үүслийн гэрчилгээтэй байх;

23.3.4. Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн гарал үүслийн гэрчилгээгүй сэлбэг хэрэгсэл, тос тосолгооны материал хэрэглэгчдэд худалдахыг хориглоно.

23. дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл

23.1. Автотээврийн хэрэгсэл өмчлөх, эзэмших эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой хуульд заасан үйл ажиллагааг автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл гэнэ.

23.2. Автотээврийн хэрэгсэл гэдэгт энэхүү хуулийн 4.1.2-т заасан болон бүх төрлийн мотоцикл, трактор, өөрөө явагч дугуйт механизмууд хамаарна.

23.3. Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, иргэд автотээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

23.4. Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааг автотээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

23.5. Зэвсэгт хүчин, хил хамгаалах байгууллагад ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл хөтлөх асуудлыг тухайн асуудал эрхэлсэн цэргийн автотехникийн хяналтын албадууд зохион байгуулна.

23.6. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл нь дараах төрөлтэй байна:

23.6.1. автотээврийн хэрэгсэл шинээр бүртгэж, бүртгэлийн дугаар олгох;

23.6.2. автотээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч;

23.6.3. автотээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасах;

23.7. Автотээврийн хэрэгслийг улсын бүртгэгч бүртгэн бүртгэлийн дугаар, автотээврийн хэрэгслийн гэрчилгээ олгоно.

23.8. Дараах автотээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэхийг хориглоно:

23.8.1. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй стандартын шаардлага хангаагүй;

23.8.2. баруун талдаа жолооны хүрдтэй автотээврийг хэрэгсэл;

(энэхүү хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс мөрдөнө.)

23.8.3. зохих хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэлт хийгээгүй, татвар төлөөгүй;

23.8.4. тухайн автотээврийн хэрэгслийн техникийн үзүүлэлт нь техникийн баримт бичигтэй зөрсөн.

23.9. Улсын бүртгэгч нь автотээврийн чиглэлээр дээд боловсролтой эсхүл эрх зүйч мэргэжилтэй, улсын бүртгэгч бэлтгэх сургалтад хамрагдсан Монгол Улсын иргэн байна.

23.10. Автотээврийн хэрэгслийн бүртгэл нь улсын хэмжээнд нэгдмэл байна.

23.11. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг, тэмдгийн үйлдвэрлэлд тавигдах шаардлагыг стандартаар тогтооно.

24. дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналт

24.1. Автотээврийн хэрэгслийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд нөлөө үзүүлэх сөрөг хүчин зүйлсийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдалд жилийн турш техникийн хяналтын үзлэг хийнэ.

24.2. Автотээврийн хэрэгсэл гэдэгт энэхүү хуулийн 23.2-т заагдсан автотээврийн хэрэгслийг хамааруулна.

24.3. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг энэхүү хуулийн 29.1.2-д заасан тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллага эрхэлнэ.

24.4. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх байгууллага нь стандартчилал тохирлын үнэлгээний хуулийн дагуу итгэмжлэгдсэн байна.

24.5. Автотээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага иргэн нь нийтийн тээврийн үйлчилгээний автотээврийн хэрэгслийг хагас жил тутамд, бусад автотээврийн хэрэгслийг жилд нэг удаа техникийн хяналтын гэрчилгээнд заасан хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамруулна.

24.6. Техникийн хяналтын гэрчилгээнд заасан хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй автотээврийн хэрэгслийг/байлдааны тусгай зориулалттайгаас бусад/ замын хөдөлгөөнд оролцохыг хориглоно.

24.7. Үйлдвэрлэгдсэнээс хойш автотээврийн хэрэгслийг эхний 2 жилд техникийн хяналтын үзлэгт хамруулахгүй.

24.8. Дараах тохиолдолд энэхүү хуулийн 24.6-т заасан хугацааг үл харгалзан автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулна:

24.8.1. хөдөлгүүр болон арлыг сольсон, нэмэлт тоног төхөөрөмж суурилуулсан, ажил үйлчилгээний шаардлагын дагуу үйлдвэрлэгчийн зөвшөөрлөөр автотээврийн хэрэгслийн зориулалтыг өөрчилсөн;

24.8.2. эзэмшигч нь хүсэлт гаргасан;

24.8.3. зам тээврийн осолд өртөж хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх агрегат, зангилаа, механизмд эвдрэл гарсныг засварласан.

24.9. Ашиглагдаж байгаад импортоор орж ирсэн автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулж, стандартын шаардлага хангуулсны дараа улсын бүртгэлд бүртгэнэ.

24.10.Зам тээврийн осол, гамшиг, аюулт үзэгдэлд өртсөн автотээврийн хэрэгслийг цаашид ашиглах эсэхэд мэргэжлийн шинжээч дүгнэлт гаргана.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Автотээврийн салбарын ажилтны давтан сургалт, мэргэжлийн зэрэг олгох

25 дугаар зүйл. Автотээврийн салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох

25.1. Автотээврийн салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, хүчингүй болгох асуудлыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл хариуцна.

25.2. Автотээврийн салбарын мэргэжилтэй ажилтны мэргэжлийн түвшинг нэгээс зургаан зэргээр тогтоох бөгөөд мэргэжлийн түвшин, үйл ажиллагааны хамрах хүрээг стандартаар тогтоож өгнө.

25.3. Автотээврийн салбарын мэргэжилтэн нь мэргэшсэн инженер, зөвлөх инженер гэсэн мэргэшлийн зэрэгтэй байна.

26 дугаар зүйл. Мэргэшсэн жолооч

26.1. Мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний жагсаалтыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

26.2. Мэргэшсэн жолоочийн үнэмлэх нь тухайн ангиллын автотээврийн хэрэгслийг жолоодох эрхийн үнэмлэхийн хамт хүчинтэй.

26.3. Мэргэшсэн жолоочийн эрх дор дурдсан тохиолдолд дуусгавар болно:

26.3.1. мэргэшсэн жолоочийн үнэмлэхийн хүчинтэй хугацаа дууссан бол;

26.3.2. автотээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхийн хүчинтэй хугацаа дууссан, эсхүл бусад үндэслэлээр хүчингүй болсон бол;

26.3.3. мэргэшсэн жолоочийн эрх дуусгавар болсон нь тухайн ангиллын автотээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хүчингүй болгох, хасах үндэслэл болохгүй;

26.3.4. мэргэшсэн жолоочийн зөрчлийн оноо тогтоосон хязгаарт хүрсэн.

26.1. Энэ хуулийн 26.3-д заасан шалтгаан арилсан нөхцөлд мэргэшсэн жолоочийн эрхийг сэргээж болно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

АВТОТЭЭВРИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

27 дугаар зүйл. Автотээврийн мэдээллийн нэгдсэн сан

27.1. Автотээврийн мэдээллийн нэгдсэн сан нь дараах төрөлжсөн сангуудаас бүрдэнэ:

27.1.1. автотээврийн хэрэгслийн мэдээллийн сан;

27.1.2. мэргэшсэн жолоочийн мэдээллийн сан;

27.1.3. ачаа тээврийн мэдээллийн сан;

27.1.4. зорчигч тээврийн мэдээллийн сан;

27.1.5. автотээврийн хяналтын мэдээллийн сан;

27.1.6. авто үйлчилгээний мэдээллийн сан.

27.2. Автотээврийн хэрэгслийн мэдээллийн санд автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл, техникийн хяналтын үзлэг, засвар үйлчилгээний мэдээллийг хамруулна.

27.3. Мэргэшсэн жолоочийн мэдээллийн санд мэргэшсэн жолооч бэлтгэх сургалт эрхлэх байгууллага, мэргэшсэн жолооч нарын нэгдсэн бүртгэл, тэдгээрт эрх олгосон ангилал, хүчинтэй хугацаатай холбогдсон мэдээллийг хамруулна.

27.4. Ачаа тээврийн мэдээллийн санд тээвэрлэгчийн мэдээлэл, ачаа тээврийн тоо хэмжээ, давтамж, хамрах хүрээ, төрөл, ангилал болон автотээврийн терминалын үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг хамруулна.

27.5. Зорчигч тээврийн мэдээллийн санд жуулчин тээврийн үйлчилгээ, нийтийн тээврийн үйлчилгээний цагийн хуваарь, үнэ тариф, чиглэл, автотээврийн хэрэгслийн байршил, хөдөлгөөнийг тодорхойлох, зохицуулах, цаг агаар, байгалийн гамшигтай холбогдсон мэдээлэл болон зорчигч тээвэртэй холбогдсон статистик мэдээллийг хамруулна.

27.6. Автотээврийн хяналтын мэдээллийн санд автотээврийн үйл ажиллагаанд гарсан зөрчил, тэдгээрт хийсэн эрсдэлийн үнэлгээ, хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд тавих хяналт шалгалттай холбогдсон мэдээллийг хамруулна.

27.7. Автотээврийн мэдээллийн нэгдсэн санг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хөтөлнө.

27.8. Автотээврийн мэдээллийн сан нь хилийн хяналтын байгууллагууд, даатгал, татвар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон бусад холбогдох байгууллагуудын сүлжээтэй уялдсан байна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

АВТОТЭЭВРИЙН СТАНДАРТЧИЛАЛ

28 дугаар зүйл. Стандартчилал

28.1. Автотээврийн стандартыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж, стандартын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

29 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл

29.1. Дор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлнэ:

29.1.1. нийтийн тээврийн үйлчилгээ;

29.1.2. автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах;

29.1.3. тээврийн хэрэгслийн бүртгэлийн дугаар үйлдвэрлэх;

29.1.4. аюултай ачаа тээвэрлэх;

29.1.5. автотээврийн хэрэгсэл, түүний эд ангийн үйлдвэрлэл, дахин боловсруулалт.

29.2. Энэ хуулийн 29.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дор дурдсан байгууллага, албан тушаалтан олгоно.

29.2.1. улс болон хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Автотээврийн зохицуулах хороо;

29.2.2. орон нутгийн нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг тухайн тээврийн чиглэл дайран өнгөрч байгаа аймаг, хотын Засаг дарга нар хамтран;

29.2.3. хот доторх болон хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг тухайн хотын захирагч.

29.3. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах, тээврийн хэрэгслийн бүртгэлийн дугаар үйлдвэрлэх, аюултай ачаа тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Автотээврийн зохицуулах хороо олгоно.

29.4. Автотээврийн хэрэгсэл, түүний эд ангийн үйлдвэрлэл, дахин боловсруулалт эрхлэх тусгай зөвшөөрлийг үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

29.5. Тусгай зөвшөөрлийг тухайн ажил үйлчилгээний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тусгай зөвшөөрөл олгох нөхцөл шаардлагыг хангасан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгоно.

29.6. Тусгай зөвшөөрөл олгохдоо дараах нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг магадлан шалгасны үндсэн дээр олгоно:

29.6.1. тусгай зөвшөөрөл авахыг сонирхогч этгээдэд тухайн ажил үйлчилгээг бүрэн, үнэн зөв гүйцэтгэх санхүү эдийн засаг, мэргэжлийн боловсон хүчний чадавх, үйл ажиллагааны үндсэн чиглэл, нэвтрүүлэх технологи, ажлын байр, тоног төхөөрөмжийн талаар тавих шаардлага;

29.6.2. тухайн ажил үйлчилгээнд мөрдүүлэхээр эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, дүрэм, журмаар тогтоосон нөхцөл.

29.7. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

29.8. Тухайн үйлчилгээг эрхлэхээр хэд хэдэн сонирхогч этгээд хүсэлт гаргасан тохиолдолд, уг ажил, үйлчилгээний эрэлт, хэрэгцээг харгалзан сонирхогчдыг сонгон шалгаруулах замаар тусгай зөвшөөрлийг олгож болно.

29.9. Энэхүү хуулийн 29.8-д заасан сонгон шалгаруулалтыг журмаар зохицуулна.

29.10. Энэхүү хуулийн 29.1-т зааснаас бусад тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэхдээ Автотээврийн зохицуулах хороонд бүртгүүлсэний үндсэн дээр эрхлэнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ

Автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэл

30 дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэл

30.1. Монгол Улсад үйлдвэрлэсэн, угсарсан автотээврийн хэрэгсэл, агрегат, эд анги нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөөгүй байна.

30.2. Монгол Улсад үйлдвэрлэсэн, угсарсан автотээврийн хэрэгсэл, агрегат, эд анги нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг бүрэн хангасан байна.

30.3. Ашиглалтаас хасагдах тээврийн хэрэгслийг зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллага дахин боловсруулалт хийнэ.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

АВТОТЭЭВРИЙН ХЯНАЛТ

31 дүгээр зүйл. Автотээврийн хяналтыг хэрэгжүүлэх

31.1. Автотээврийн хяналтыг автотээврийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, стандарт, норм, нормативын хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр хэрэгжүүлнэ.

31.2. Автотээврийн улсын хяналтыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Улсын хяналтын алба, автотээврийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

31.3. Автотээврийн улсын хяналт нь автотээврийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, стандарт, норм, нормативын хэрэгжилтийг бүрэн хамарна.

32. дугаар зүйл. Автотээврийн хяналтын улсын байцаагч

32.1. Автотээврийн хяналтын улсын ерөнхий байцаагч нь автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

32.2. Автотээврийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар, ахлах байцаагч, байцаагчийн эрхийг ерөнхий байцаагч тус тус олгоно.

32.3. Автотээврийн хяналтын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.3.1. автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ автотээврийн хэрэгслийг түр зогсоож шалгах, шаардлагатай гэж үзвэл тухайн автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, жолоодох эрхийн үнэмлэх, мэргэшсэн жолоочийн үнэмлэх, тээврийн баримт бичгийг уг зөрчлийг шийдвэрлэж дуустал түр хураах;

32.3.2. мэргэшсэн жолоочийн эрхийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх талаар эрх бүхий байгууллагад санал оруулах.

32.3.3. автотээврийн тухай хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг өөрийн эрх мэдлийн хүрээнд авах;

32.3.4. автотээврийн тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах.

32.3. Автотээврийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч нь энэ хуулийн 32.3-т зааснаас гадна Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.12-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

32.4. Автотээврийн хяналтын улсын байцаагчийн хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд өгсөн үүрэг, тавьсан шаардлагыг холбогдох иргэн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй.

32.5. Автотээврийн хяналтын улсын байцаагч нь албан үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай техник хэрэгслээр хангагдана.

32.6. Автотээврийн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батална.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

33 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

33.1. Автотээврийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

34 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

34.1. Энэ хуулийг 2017 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ